

# Цахим орчинд хүүхдээ хүчирхийлэл, дарамтаас хэрхэн **хамгаалах** вэ?

Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан  
гарын авлага

“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл



Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурал, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Энэхүү гарын авлагыг Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй, НҮБ-ын “Итгэлцлийн сан”-гийн санхүүжилттэй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд боловсруулав.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар- 13, Монгол Улс| Утас: +976-11-329371, 329365 | Факс: : +976-11-329361 | Цахим шуудан: [Mongolia.secretary@savethechildren.org](mailto:Mongolia.secretary@savethechildren.org) | Гарын авлагыг цахим хэлбэрээр [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn) вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол улс

2024 он

## ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

Цахим орчин нь зөвхөн мэдээлэл авах, байршуулах, түгээх хэрэгсэл байхаа болиод удаж байгаа бөгөөд харин бид өдөр тутамдаа бусадтай цаг алдалгүй харилцахдаа хэрэглэгдэг харилцааны нэг төрөл болсон. Цахим орчин нь бидэнд мэдээллийг хурдан шуурхай хүлээн авах, илгээх, цагийг зугаатайгаар өнгөрүүлэх, алс хол байгаа найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ дүрсээ харан холбогдох гэх зэрэг олон давуу талтай боловч нөгөө талаас гэмт хэрэг үйлдэх, бусдыгаа доромжлох, гутаах, дарамтлах хэрэгсэл болсон.

Дийлэнх хүмүүс олон нийтийн сүлжээ буюу бидний хэлж заншсанаар сошиал медиа сувгуудыг хэрэглэхийн тулд имэйл хаяг эсвэл утасны дугаараа ашиглан бүртгэл, хаяг үүсгэх боломжтой. Та хүсвэл олон нийтийн сүлжээний аль ч сувгуудаар, хэдэн ч хаягаар зураг, богино бичлэг хуваалцаж, эсвэл нийтлэл бичиж, сэтгэгдлээ илэрхийлж эсвэл бусад хэрэглэгчтэй холбогдож, харилцаа холбоо тогтоож болно. Олон нийтийн сүлжээнд бүртгэл хийхэд заавал өөрийн бодит мэдээллийг оруулж, өөрийгөө хэн гэдгээ баталгаажуулах шаардлагагүй тул хүн өөрийн хүссэнээр ямар ч байдлаар, хэдэн ч бүртгэл үүсгэх боломжтой. Жишээ нь Африкийн нэг улсын 60 настай эрэгтэй 16 настай ази эмэгтэй хүүхдийн мэдээлэл бүхий бүртгэл үүсгэх бүрэн боломжтой гэсэн үг юм.

- Өнөө үед харилцаа холбоо, мэдээлэл технологийн маш олон сүлжээ, вебсайт, аппликейшн бүтээгдсээр байна.
- 2023 оны байдлаар дэлхийн интернэт хэрэглэгчдийн тоо 6 тэрбум 300 сая хүрсэн.
- Нийт интернэт хэрэглэгчдийн 92.6% буюу 4 тэрбум 960 сая олон нийтийн сүлжээг ашиглаж байна.
- Олон нийтийн сүлжээ хэрэглэгчдийн 80.8% нь насанд хүрсэн хүмүүс байна.
- Internet Watch Foundation (Их Британи улсад төвтэй байгууллага) 2021 онд хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой зураг агуулсан 252,000 цахим холбоосыг устгажээ.
- INHOPE (CSAM мэдээллийг цахим орчноос устгах үйл ажиллагаа явуулдаг) олон улсын сүлжээ байгууллагын мэдээлснээр 2020 онд 47 орны (ЕХ-ны бүх улс багтсан) цахим орчинд байршсан 1,038,268 хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийг устгасан байна.

## **ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХЭД ЯМАР ТӨРЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ДАРАМТАД ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ ВЭ?**

Ямар ч төрлийн хүчирхийлэл нь хүний сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Цахим орчинд бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдийн сэтгэл зүй, зан үйлд дараах ерөнхий шинж тэмдгүүд ажиглагддаг. Үүнд:

- Цахим бэлгийн хүчирхийлэл, дарамт
- Цахим бэлгийн мөлжлөг
- Цахим дээрэлхэл, дарамт

## **ЦАХИМ ОРЧИНД ХҮЧИРХИЙЛЭЛ, ДАРАМТ ХААНА ҮЙЛДЭГДДЭГ ВЭ?**

- Олон нийтийн сүлжээний сувгууд (Фэйсбүүк, Инстаграм, ТикТок гэх мэт)
- Мессеж
- И-мэйл
- Цахим чатууд (Мессенжер, Инстаграм, Чат гэх мэт)
- Streaming буюу шууд дамжуулалтын үеэрх сэтгэгдлүүд
- Online game буюу цахим тоглоомын үеэр хоорондоо ярих, бичих

## **ЦАХИМ ДЭЭРЭЛХЭЛ ГЭЖ ЮУ ВЭ? ХЭРХЭН ТАНИХ ВЭ?**

Цахим дээрэлхэл гэдэгт хэн нэгний эмзэг, хувийн эсвэл худал мэдээллийг тухайн хүнийг доромжлох, гутаах, заналхийлэх, эвгүй байдалд оруулах гэх мэт зорилгоор олон нийтийн сүлжээнд санаатайгаар нийтлэх, бусдад илгээх, түгээх үйлдлүүд багтдаг. Өсвөр насны хүүхдийн дунд энэ төрлийн дээрэлхэл нь түгээмэл асуудал болсон бөгөөд ихэнх тохиолдол дараах байдлаар үйлдэгддэг. Үүнд:

- Фэйсбүүк, Инстаграм, ТикТок гэх мэт олон нийтийн мэдээллийн сүлжээгээр
- Хүүхдийн өөрийн нийтэлсэн зураг, бичлэг, эсвэл reels, story гэх мэт мэдээллийн дор хэн нэгнийг гутаан доромжилсон, эвгүй байдалд оруулсан, заналхийлсэн сэтгэгдэл үлдээх
- Хувийн цахим чатаар гутаан доромжилсон, эвгүй байдалд оруулсан, заналхийлсэн өнгө аястай аудио, текст мэссэж илгээх
- Интернет сүлжээгээр холбогдож тоглож байх явцадаа аудио болон текст хэлбэрээр бусад тоглож буй хүүхэд рүү зүй бус үг хэллэг хэрэглэх, хараах, доромжлох
- Discord, Reddit, Quora, Steam Chat гэх мэт цахим форум буюу хэлэлцүүлгийн сүлжээгээр зүй бус үг хэллэг хэрэглэх, хараах, доромжлох



- Гар утасны мессежээр доромжилсон, дээрэлхсэн, эсвэл заналхийлсэн зурвас илгээх

## **ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХДИЙН ЭСРЭГ ЯМАР ТӨРЛИЙН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ДАРАМТ ҮЙЛДЭГДДЭГ ВЭ?**

### **1. Cyber-grooming буюу цахимаар дотносож, хүчирхийлэх**

Насанд хүрсэн хүн дийлэнх тохиолдолд өөрийн жинхэнэ бус хуурамч хаягаас хүүхэдтэй сошиал сувгуудаар дамжуулан найзын хүсэлт илгээн, найз болж, бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл, хүний наймаа хийх зорилготойгоор дотносох, нөхөрлөх явдал юм. Тэд эхэндээ найрсаг, нөхөрсөг харилцаа тогтоон, улмаар хүүхдийн итгэлийг олж авсныхаа дараа хүүхдээс хувийн мэдээлэл, бэлгийн харилцааны шинж чанартай – нүцгэн зураг, бичлэг гэх мэт эмзэг мэдээллийг нь авдаг. Улмаар энэхүү мэдээллийг нь бусдад түгээнэ гэж хүүхдийг заналхийлж, дарамталдаг.

### **2. Sexting буюу бэлгийн шинж чанартай дуу, дүрс бүхий мессеж илгээх**

Sexting гэдэг нь “секс” болон “мессеж бичих” гэсэн 2 үгнээс бүрдсэн бөгөөд энэхүү хэллэг нь өөрийнхөө нүцгэн эсвэл хагас нүцгэн зураг, бичлэгээ хэн нэгэн рүү “сайн дурын” үндсэн дээр илгээх, хүлээн авахыг хэлдэг. Ихэвчлэн насанд хүрэгчид ашигладаг боловч сүүлийн жилүүдэд өсвөр насныхан “нүцгэн” эсвэл “тачаангуй” гэж бодсон зураг, бичлэгээ бусад хүмүүст илгээж, бусдад хэр тачаангуй харагдахыг туршиж үзэх хандлага ихэссэн. Улмаар энэхүү бичлэг нь санаатай болон санамсаргүй байдлаар олон нийтийн сүлжээнд тархдаг.

### **3. Sextortion буюу бэлгийн шинж чанартай бичлэг, дүрсийг нь ашиглаж дарамтлах**

“Sextortion” гэдэг нэр томъёо нь “секс” болон “шантаажлах”, “дарамтлах” гэсэн хоёр үгнээс бүрдсэн бөгөөд энэ нь хүүхдийн итгэлийг олж авсны дараа хүүхдийн царай гарсан ил тод гарсан, нүцгэн эсвэл эмзэг зураг, бичлэг хийлгэн, өөрийн болгодог. Хүүхдээс олж авсан энэхүү мэдээллээ олон нийтийн болон бусад сүлжээнд нийтэлдэг эсвэл худалддаг. Мөн хүүхдийн зургийг олон нийтийн сүлжээнд тавина хэмээн дарамталж мөнгө нэхэх, өөр зураг, бичлэг хийж өгөх, эсвэл өөрийн хүссэн зүйлээ хийхийг шаардаж, дарамталдаг.

### **4. Deepfake буюу хиймэл оюун ухаан ашиглан зураг эсвэл бичлэгийг хиймлээр бүтээх**

Хүмүүсийн цахим орчинд байршуулсан зургаас нүүрний хэсгийн зургийг ашиглан царайны ерөнхий хэлбэрийг бүтээж, ямарваа нэгэн үйлдэл хийж байгаа мэтээр харуулах

нь ихэссэн. Өөрөөр хэлбэл бусдын зургийг зөвшөөрөлгүй ашиглан худал мэдээлэл, хүчирхийлэлтэй холбоотой контент бүтээж, нийтлэх, түгээх эрсдэлтэй.

## **5. Бусдын мэдээлэл, зургийг зүй бусаар ашиглах**

Цахим орчинд байрлуулсан бусад хүмүүсийн хувийн мэдээлэл, зураг зэргийг зөвшөөрөлгүй хуулбарлан бусдыг хүчирхийлэх, дарамтлах, хууран мэхлэх гэх мэт зорилгоор өөр хаяг үүсгэдэг. Мөн уг хаягаа хүүхдийн эмзэг хувийн мэдээлэл, зураг, хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийг цахим орчинд санаатайгаар нийтлэх, түгээх, худалдах зорилгоор ашигладаг. Сүүлийн үед хуурамч хаяг нээн, өвчтэй хүүхдийн мэдээллийг ашиглан бусдаас их хэмжээний хандив цуглуулсан, залилангийн гэмт хэрэг үйлдэгдэх болсон.

## **ЦАХИМ ОРЧИНД БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ДАРАМТАД ӨРТСӨН ХҮҮХДЭД ЯМАР ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРДЭГ ВЭ?**

Ямар ч төрлийн хүчирхийлэл нь хүний сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Цахим орчинд бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдийн сэтгэл зүй, зан үйлд дараах ерөнхий шинж тэмдгүүд ажиглагддаг. Үүнд:

- Найз нөхөд, гэр бүлийнхнээсээ харилцаа холбоогоо таслах
- Гэр бүл, найз нөхдөөсөө ямар нэг зүйл нуух
- Олон хаяг ашиглах, хаягаа олон давтамжтай солих
- Цахим сүлжээнд гэр бүл, найз нөхдөө найзаасаа хасах, блоклох
- Айдас, түгшүүртэй болох
- Сэтгэл гутралд орох
- Сэтгэл санаа тогтворгүй болж, хямрах
- Бусдад үл итгэх, өөрийгөө тусгаарлах, ганцаардах
- Өөртөө итгэлгүй болох, сэтгэлээр унах
- Өмнө нь хийдэг байсан дуртай зүйлээ хийхгүй болох
- Бусдаас ичих, өөрийгөө гэм буруутай гэж бодох
- Шалтгаангүй уурлах, бухимдах нь ихсэх
- Өөрийгөө гэмтээх, амиа хорлох талаар бодох, оролдох

## **ХҮҮХЭД ТАНЬ ЦАХИМ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ДАРАМТАД ӨРТСӨН БОЛ ТА ЮУ ХИЙХ ВЭ?**

- Хүүхдийг шүүмжилж, буруутгахгүйгээр сонсох
- Хүүхдийн тусламжийн 108 утас болон цагдаагийн шуурхай тусламжийн 102 утсанд хандах
- Хүчирхийлэгчийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр блоклох



- Хүүхдийг шүүмжилж, буруутгахгүйгээр сонсох
- Хүүхдийн тусламжийн 108 утас болон цагдаагийн шуурхай тусламжийн 102 утсанд хандах
- Хүчирхийлэгчийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр блоклох
- Хүүхэд цахим бэлгийн хүчирхийлэлд өртсөн, цахим бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой зураг, бичлэг, аудио гэх мэт мэдээллийг <https://report.iwf.org.uk/mn> вэбсайтад хандаж, тухайн мэдээллийг устгах хүсэлтээ өгч болно. Илгээгчийн хувийн мэдээллийг нууцлах тул бусад хүнд харагдахгүй.

## **ХҮҮХДИЙГ ЦАХИМ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ДАРАМТАД ӨРТӨХӨӨС ЯАЖ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ, ХАМГААЛАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?**

- Эцэг эх, асран хамгаалагчид өөрсдөө цахим орчны аюулгүй байдлын талаарх мэдлэгээ нэмэгдүүлэх, аюулгүй байдлын тохиргоо хийж сурах.
- Өдөр тутам хүүхдэдээ цаг гаргаж, ярилцах.
- Хүүхэдтэйгээ хамт цагийг чанартай өнгөрөөхөд анхаарах.
- Хүүхдэд цахим орчин дахь аюулын талаар ойлгуулах, цахим орчныг аюулгүй ашиглахад нь туслах.
- Цахим орчинд үл мэдэх, сэжиг бүхий вебсайт/хүмүүст хувийн мэдээлэл өгөхгүй байх, нууц үгээ байнга солих, цахим контентыг татаж авахад анхаарах зүйлс зэрэг интернэтийн аюулгүй хэрэглээний талаар зааж сургах.
- Хүүхдийн цахим үйл ажиллагаа, хэнтэй харилцаж байгааг хянах.

## **ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ ТА ЦАХИМ ОРЧИН ДАХЬ АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХЭРХЭН ХАНГАХ ВЭ?**


- Фэйсбүүк, Инстаграм, ТикТок гэх мэт олон нийтийн сүлжээний нууцлалын тохиргоо, давхар хамгаалалтыг хийх
- Цахим орчинд хүүхдийнхээ тухай зураг, бичлэг, гэрийн хаяг гэх мэт хувийн шинжтэй мэдээлэл аль болох оруулахгүй байх
- Үл таних, сэжиг бүхий групп, пэйж, хаягийг блоклох, дагахаа болих, найзаас хасах, репортлох:
- Гар утас, таблет, компьютер гэх мэт ухаалаг төхөөрөмжийн аюулгүйн тохиргоог хийж сурах
- Цахим зар сурталчилгаа дээр дарахгүй байх, баталгаагүй, хортой программуудыг суулгахгүй, нэвтэрч орохгүй байх, хувийн мэдээллээ хуваалцахгүй байх
- Гар утас, таблет, компьютер гэх мэт ухаалаг төхөөрөмждөө вирусийн эсрэг программ суулгах

- Гар утас, таблет, компьютер гэх мэт ухаалаг төхөөрөмждөө нэвтрэх нэр, нууц үгээ бусадтай хуваалцахгүй байх, хамгаалалт сайтай нууц үгийн бүтэцтэй байх

## ЭЦЭГ ЭХИЙН ХЯНАЛТЫН ТОХИРГОО/СИСТЕМ ГЭЖ ЮУ ВЭ?


iPhone гар утсан дээр тохируулах заавар:

1. Family Sharing буюу гэр бүлийн тохиргоонд хүүхдээ нэмэх




Өөрийн профайл руу орно.

Профайл руу орсны дараа Family Sharing товч дээр дарна.




Баруун дээд булан дахь товч дээр дарна.



### 4 Invite Family

You can add up to five more people to your family.


Хүүхдийнхээ хаягийг гэр бүлийн бүртгэлд урих эсвэл шинэ хаяг нээнэ.



Child accounts can be created by a parent or legal guardian for children aged 12 or younger.





## 2. Screen Time буюу дэлгэцийн хяналтыг идэвхжүүлэх




Settings хэсгээс Screen Time-г сонгоно.

Screen Time товчийг дарж орсны дараа та өөрийнхөө эсвэл хүүхдийн утсыг сонгож, Passcode буюу нууц тоо оруулж, идэвхжүүлнэ.




Screen Time доторх Content and Privacy Restrictions товчийг дарна.

Энэхүү тохиргоог идэвхжүүлснээр хүүхдийн байршил, утасны жагсаалт, календар, зургийг харах, зөвшөөрөх аппликейшныг тохируулж болно.




Андройд гар утсан дээр Google Family Link буюу гэр бүлийн бүртгэл тохируулах заавар

1. Google Family Link буюу гэр бүлийн бүртгэлийн аппликейшн татах:



Google Play Store-оос “Google Family Link” аппликейшныг татна уу.


Аппликейшнээ нээн өөрийнхөө хаягийг сонгон “Continue” товчийг дарна уу.




3

Does your child have a Google Account?

They'll need an account ending in @gmail.com in order to set up supervision for them



Хэрвээ таны хүүхдэд Google хаяг байгаа бол “Yes” товчийг дарж, цааш үргэлжлүүлэх, үгүй бол “No” товчийг дарж, шинэ хаяг үүсгээрэй.



## ЭЦЭГ ЭХИЙН ХЯНАЛТЫН ТОХИРГОО/СИСТЕМ ГЭЖ ЮУ ВЭ?

### 2. Google хүүхдийн хаяг нээх заавар

1  
Google  
Sign in  
to continue to Gmail

Email or phone

[Forgot email?](#)

Not your computer? Use Guest mode to sign in privately.  
[Learn more](#)

Create account

Next

For myself  
For my child  
To manage my business

Та [www.accounts.google.com](http://www.accounts.google.com) холбоосоор орж, "Create Account" товчийг дарж, For my child-ыг сонгоно уу.

Child account нь 13 болон түүнээс доош насны хүүхдэд зориулсан бөгөөд та үргэжлүүлэхийг хүсвэл "Yes, Continue" товч дээр дарна уу.

2  
Google  
Create a Google Account  
You'll help manage this account until your child is 13 (or applicable age in your country)

- Manage your child's account and privacy settings
- Set content filters for services like Google Play and Search that work when your child is signed in
- Limit screen time on supervised devices with Google Family Link. [Learn more](#)

No thanks

Yes, continue

3

Casey

Beckett

CaseyB\*\*\*\* @gmail.com

You can use letters, numbers & periods

.....

.....

Use 8 or more characters with a mix of letters, numbers & symbols

Show password

Sign in instead

Next

Энэхүү хэсэгт хүүхдийн овог нэр, нэвтрэх нэр, нууц үгийг оруулна.

4



### Basic information

Enter Casey's birthday and gender

Month  Day  Year   
 Birthday

Gender

Хүүхдийн нас, хүйсийн талаарх мэдээллийг оруулсны дараа "Next" товчийг дарна уу.



Why we ask for this information

Back



5



### Parent sign-in

A parent must help Casey manage her Google Account until she turns 13 (or applicable age in your country).

Parent email or phone number   
 Enter the account you'll use to manage Casey's account.



Энэхүү хэсэгт та өөрийн Google хаягийг оруулна уу.



6

I understand that my child's Google Account is like my own and will provide access to general audience services that have not been designed for children and that will enable my child to do things like communicate with others and see content I may consider inappropriate. I also agree to the [Google Terms of Service](#), the [YouTube Terms of Service](#), and the [Google Play Terms of Service](#) on behalf of my child and understand that all terms apply to my account and to the account I create for my child.



Та үйлчилгээний нөхцлийг зөвшөөрч байвал "Agree" товчийг дарна уу.



Do you agree?

To create an account for your child, you must agree to the Parental Consent and sign in on the next screen to verify you're a parent.

Cancel





7

### Enter your password

elisa.g.beckett@gmail.com

When you enter your password, you confirm that you agree to the [Parental Consent](#) and want to create a Google Account for Casey.

Next, Google will check your Google Account info to verify you're a parent. [Learn more](#)

Enter your password [password field]  
 Show password

[Forgot password?](#)



Та нууц үгээ оруулж, баталгаажуулна.



8

### What parents can manage

Until Casey reaches 13 (or applicable age in your country) and decides to manage her account on her own, you can do things like:

- **Update your child's account info & some settings**  
Like her name and birthday.
- **Delete her account**  
You can recover her account for a limited period of time after you delete it.
- **Manage her activity controls**  
You can manage settings like how Google collects your child's Web & App Activity.

Family Link offers more parental controls and supervision features, but they only work on certain devices. Family Link's default settings will apply until you customize them. [Learn more](#)



Та хүүхдийн дараах мэдээллүүдийг удирдаж болно.

- Нэр, төрсөн өдөр
- Хүүхдийн хаягийг устгах
- И-мэйл, байршил, зургийн зөвшөөрөл гэх мэт



Та амжилттай Google хүүхдийн хаяг үүсгэлээ.



9



### You created a Google Account for Casey

You'll receive an email with more information about Casey's new account





Save the  
Children

